

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН
БИЕИЙН ТАМИРЫН БАГШ Г.ГҮНСЭНХОРОЛ 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН
ТАЙЛАН

➤ **СУРГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

* Сургалтын хөтөлбөрийг хүүхдийн бие, бялдар оюун ухаан сэтгэл зүй, нийгэмшихүйн хөгжил, тэдний хэрэгцээ сонирхолд тулгуурлан боловсруулсан арга зүй: Сургалтын хөтөлбөрийг “Суралцагч бүрийн сурлагын чанарт ахиц гаргах, сургуулийн зорилгын хүрээнд сурагч нэг бүрийн бие бялдрыг сайжруулах, чадвараа хөгжүүлэх , “Шинжлэх ухаан ч арга барилд суралцаж, эрүүл харилцаатай хүүхэд болгон төлөвшүүлнэ. гэсэн суурь боловсролын хөтөлбөрийн зорилго “Эрүүл чийрэг, амьдрах чадвартай, өөртөө итгэлтэй шийдвэр гаргах чадвар бүхий иргэн төлөвшүүлнэ” гэсэн бүрэн дунд боловсролын зорилго гэсэн хүрээнд хөтөлбөрөө төлөвлөн ажиллаж байна. Сургалтын хөтөлбөрийг боловсролын стандартад тулгуурлан боловсруулсан байдал: Суурь боловсролын сурагчдад Мэдрэн төсөөлөх, Гүйцэтгэн эзэмших, Бүтээлчээр хөгжүүлэх, Хэвшин илэрхийлэх гэсэн үе шатаар чадварыг олгох, Бүрэн дунд боловсролын сурагчдад спортын төрлүүднн техникийг эзэмшүүлэх гэсэн стандарт хөтөлбөрийн дагуу боловсруулан хичээл сургалтаа тасралтгүй явуулж байна. Үндэсний сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг үндэслэн сургалтын байгууллагын хөтөлбөрийг боловсруулсан байдал


✓ Нэгж хичээлийн боловсруулалт

Биеийн тамирын хичээлийг 1,2,5,6 ангид нийт 32 нэгж хичээлийн боловсруулалт хийв.

Сургалтын хөтөлбөрийн дагуу хичээл зааж 10 бүлэгт 638 цагийн хичээлийг заалаа.

3.СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ

1б анги 57 сурагч сайн, 1г анги 56 сурагч сайн, 2в анги 65 сурагч сайн 2г анги 65 сурагч сайн 2е анги 65 сурагч сайн, 5а анги 54 сурагч VIII-54, 5б анги 54 сурагч VIII-54, 5ё анги 59 сурагч VIII-59, 6а анги сурагч 59 сурагч VIII- 38, VII-21, 6б анги сурагч 60 сурагч VIII- 35, VII-25,




Хичээлийн жилд 638 суралцагч дүгнэгдлээ. сурагчдын гүйх болон алхах, харайх чадвар дүгнэхээс гадна онолын мэдлэгийг 8 асуултаар шалгалаа. хичээлээс гадуурх үйл ажиллагаанд анги хамт олонтойгоо хамтран оролцож байгаа байдал хичээлд хэрхэн идэвхтэй оролцлоо. Тухайн суралцагчийн ганцаарчлан гүйцэтгэх практик чадварыг үнэллээ. Энэ хичээлийн жилд үнэлгээг 8 түвшингээр үнэлж байна. Онолын хичээлийг үр өгөөжтэй өгөх нь хамгийн чухал гэдгийг ойлгон, онолын хичээлийг нэлээд түлхүү орлоо. Сурагч нэг бүрийн бие бялдрын хөгжлийг сайжруулахад анхаарч ажиллаа. Зааланд цагийн хуваарийг бүлэг бүлгээр нь тавих нь хичээл үр дүнтэй болох нэг алхам юм.

ОНОШЛОГООНЫ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

№	Анги бүлэг	VIII	VII	VI	V	IV	III	II	I
1	5а	9	11	15	15	4	-	-	-
2	5б	5	12	18	15	4	-	-	-
3	5ё	8	13	17	20	2	-	-	-
4	Нийт	22	36	50	50	10	-	-	-
5	6а	6	8	15	16	14	-	-	-
6	6б	4	10	10	30	7	-	-	-
7	Нийт	10	18	25	46	21	-	-	-
8	Бүгд	32	54	75	96	31	-	-	-

АНГИ БҮЛГИЙН НЭГТГЭЛ



ОНОШЛОГОО ҮНЭЛГЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

№	Улирал	Сурагчдын тоо	VIII	VII	VI	V	IV	III	II	I
1	Оношлогоо	288	54	75	96	29	-	-	-	-
2	Жилийн эцэс	286	240	46	-	-	-	-	-	-

Дэмжлэг хэрэгтэй сурагчидтай ажилласан байдал

6Б Чингүүн хөлний гэмтэлтэй Өөрийн хүсэлтээр спортын төрлөөр бие даалт хийж тухайн хичээлээрээ асуугдах харилцан ярилцах, гэрээр биеийн ерөнхий хөгжлийн дасгал гүйцэтгэх зэргээр хичээлд хамруулж байна. Хичээлд тогтмол орж ирдэг. 6а Хүслэн зүрх эмчилгээтэй байгаа, Эмчийн хяналтанд тодорхой хугацаанд биед тохирсон дасгалаар хичээллэх зөвөлгөө өгөв. Эдгээр сурагчид нь биеийн тамирын хичээл дээр шатар, даам тоглох, өвөл, зуны олимп болсон газар оныг цээжлэх спортын төрлөөр бие даалт хийж тухайн хичээлээрээ асуугдах харилцан ярилцах, гэрээр биеийн ерөнхий хөгжлийн дасгал гүйцэтгэх зэргээр хичээлд хамруулж байна. Бие даалтаар биеийн тамирын хичээлийн дүнгээ авна.

3.1 ТӨЛӨВШИЛ: Оролцоо Сургалтын үйл ажиллагаанд тасралтгүй идэвхитэй оролцдог болох Бүрэн дунд боловсролд 1а, 1б, 2в, 2г, 2е, анги 100% ирцтэй хамрагддаг боллоо 5а, 5б, 5ё, 6а, 6б ангид тогтмол 3-4 сурагч, шалтгаангүйгээр хичээлд оролцохгүй байна. Цаашид эдгээр сурагчдад анхаарч ажиллах хичээлд бүрэн хамруулах. хичээлээс гадуур зохион байгуулж буй үйл ажиллагаанд анги бүлгээрээ идэвхтэй оролцдог боллоо.

Хэвшил дадал: Биеийн тамирын хичээлийн бэлтгэлийг бүрэн хангах. Дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх Ганцаарчилж хийх даалгаварыг хийхдээ сул байсан бол багаараа хийх даалгавар өгсөн нь маш үр дүнтэй хийхэд ахиц гарч бүрэн хийж хэвшлээ. Жагсаалч байдалд хэвшлээ. Өөрт тохирсон дасгал хөдөлгөөнийг дэс дараалалтай хийж байна. Жижүүр сурагч тогтмол ажиллаж байна.

Зан чанар: Өөртөө болон бусдад хүндэтгэлтэй хандах Хичээлийн явцад бие биедээ шаардлага тавьдаг, бие биенийхээ шаардлагыг сонсдог. Багшийн үгийг хүлээцтэй сонсдог боллоо. Хоцорч буй болон тасалсан сурагчдад ангиараа шаардлага тавьдаг боллоо.

Сурагч бүрийн авъяасыг хөгжүүлсэн байдал: Сурагч бүр хичээлд идэвх санаачлагатай оролцох 5, 6, ангийн сурагчдаас спортын судалгааг авч, хөл бөмбөг, шатар, сагсан бөмбөг, волейбол болон бусад спортын секц дугуйланд хамруулж байна. Аливаа хичээлд хандах хандлагыг шинэчлэх Биеийн тамирын судлагдахууны хувьд сурагчдын хандах хандлага өөрчлөгдсөн бөгөөд сурах үйл ажиллагаанд аа дүгнэлт хийн, мэрийж байгаа сурагчдын тоо эрс нэмэгдсэн. Спорт болон Биеийн тамираар хичээллэх нь ямар ач холбогдолтойг суралцагч бүр бүрэн ойлгодог боллоо.

Авъяасыг хөгжүүлсэн байдал

Чингэлтэй дүүргийн Ногоон гэрэл Цагаан шугам тэмцээнд 5 дугаар ангийн сурагчид амжилттай оролцож 2 байрт шалгарсан. Чингэлтэй дүүргийн “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм” Дэвжээ тэмцээнд 2-р байр мөнгөн шагнал. Чингэлтэй дүүргийн аврага шалгаруулах “Таеквондо” тэмцээнд 8а ангийн сурагч Ц. Камал 2-р байр мөнгөн медаль.

3.4. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ Сурагч бүрийн эрүүл мэндийг хамгаалахад оруулсан хувь нэмэр Эрүүл бие Гарын ариун цэвэр эрүүл байхын үндэс Бүх сурагчид нойтон сальфеткаар байнга гараа арчиж байна. авч явж хэвшсэн. Хичээл орж буй ангийн сурагчиддаа цэвэрлэгээний дараагаараа сайн угааж байхыг зөвлөдөг. Эрүүл харилцаа: Бие биенээ хүндэтгэн харьцдаг, сонсдог байх Этгээд болон хараалын үг хэллэг хэрэглэхгүй, сурагчид бие биендээ хүлээцтэй хандаж сонсож сурлаа. Эрүүл аюулгүй байдал Сургууль болон анги танхимаа өөрийн гэр мэт хайрлах сэтгэлгээтэй болох Бэлтгэлийн хувцасаа тогтмол солих, хэрэглэл материалтай зөв, багшийн зааврын дагуу хэрэглэх хуурах,

өөрөөрөө болон хамт олноороо бахархаж, сэтгэл хангалуун суралцахад хувь хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгож сурагчид хуурай хогоо хогын саванд хийж сурлаа. Мөн 1 ангийн 112 сурагч, 2-р ангийн 195 сурагч, 5-р ангийн 167 сурагч, 6-р ангийн 119 сурагч нийт 593 сурагч өндөр жингийн судалгааг авч сурагч бүр өөрсдийн өндөр жинг мэдэж авлаа.

3. 5. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ

Багшаас боловсролын үйлчилгээ авсан талуудын сэтгэл ханамж Сурагчийн сэтгэл ханамж Сургалтын үйл ажиллагааны үр дүнд сурагчид сэтгэл хангалуун байх Хичээлд оролцох оролцоо нэмэгдэж, хоцрогдолоо арилгах арга барил эзэмшлээ, бие даан ажиллах чадвараа өсгөж байна. Өөрийн хийж байгаа дасгал хөдөлгөөндөө үнэлгээгээ өгөх чадвартай боллоо. Эцэг эхийн сэтгэл ханамж Сургалтын үйл ажиллагааны үр дүнд эцэг эх сэтгэл хангалуун байх Хүүхдийнхээ сургалтын үйл ажиллаанд оролцож, хичээлд сууж байна. Ганцаарчилж болон багш нарын зөвлөгөөний хурлаар хүүхдийн чадварын талаар зөвлөгөө заавар өгч ажиллаа. Мөн эцэг эхчүүд хичээлд сууж багштай хамтран ажиллаж байна.

4.1 Мэргэжлээрээ өөрийгөө хөгжүүлсэн байдал

- Луужин стратеги” сэдэвт лекц
- Эерэг бол Гое сургалт
- Эко сургалт
- ӨНХ дундах дээрэлхэлтээс сэргийлэх сургалт
- Багшийн ёс зүйн дүрэм багшийн хөгжлийг дэмжих тухай сургалт
- Оюунаа цэнэглэцгээ
- Эрүүл мэнд гоо сайхан
- Өсвөр насны сурагчдын үе тэнгийн дарамт урьдчилан сэргийлэх

4.4 Багш нарын хамтын ажиллагаа

* БТ-ын багш нарын хамтлаг хурлаар 2018-2019 оны ажлын төлөвлөгөөг гаргав. 5-р ангийн багш нартай ногоон гэрэл цагаан шугам тэмцээнд бэлдсэн
Технолонийн багш нартай хамтран Мөсөн хотхон бүтээсэн.

4.5 Сургууль олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал

24-р сургуулийн заалний нээлт, 57-р сургуулийн заалний нээлт, Шатарын тэмцээн, Дэлүүн болдог яруу найргийн тэмцээн, САШСБТэмцээн, Мөсөн хотхон барих ,Хайрхан хөгжил төвийн нээлт, Ногоон гэрэл Цагаан шугам тэмцээн, Бага ангийн багш нарын Волейболын тэмцээн, Оюуны элч шагнал гардуулах ,Шинэ жилийн үйл ажиллагаа, ҮЭ-ээс зохион байгуулсан сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээн, 5 жилийн үндсэн сургалтанд хамрагдсан, ДҮАШ багш нарын сагсан бөмбөг, волейболын тэмцээн, 50-р сургуулийн нэрэмжит “Залуу багш” спортын 3 төрөлт тэмцээнд амжилттай оролцов,ДҮАШ гимнастик аеробикийн тэмцээнд дунд, ахлах насны сурагчдыг бэлтгэн оролцуулсан, Гамшигаас урьдчилан сэргийлэх сургалтад НБГазраас параданд алхсан, Чингэлтэй дүүргийн

“Өсвөрийн сэргийлэгч бүлгэм” Дэвжээ тэмцээнд 2-р байр мөнгөн шагнал зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж оролцов.

5. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ ,ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТ : 2018-2019 оны хичээлийн жилд нийт 10 бүлгийн 593 сурагчид 638 цагийн биеийн тамирын хичээл орж хамтран судлаж, ажиглан үнэлгээ хийв. Сурагч нэг бүрийг хөгжүүлэх, Үүний үр дүнд сурагчдын хичээлд хандах хандлагад өөрчлөлт гарч Сурагчид хичээлийн бэлтгэл хангахын хирээр өөрийгөө үнэлэх чадварт суралцсан тодорхой зорилго тавин түүндээ хүрэх хүсэл эрмэлзэлтэй болсон гэж дүгнэж байна хүүхдэд сурах хүсэл тэмүүлэл бий болгох нь хүүхэд бүрийг өөрийн зорилго үүргийг ухамсарлан, аливаа үйл ажиллагаанд оролцох хүсэл эрмэлзэл дүүрэн, чин сэтгэлээсээ чармайн ажиллаж, өөрийн чадвараа хөгжүүлэн, ахиц амжилттай суралцаж байна. Мөн баг хамт олноороо суралцсан, тоглоом болон тэмцээний аргаар хичээл сургалтаа явуулсан нь үр дүнгээ өгч байна. Багш хоорондоо хамтран ажиллах чадварт илүү суралцах нь бие биенээсээ туршлага судлах, суралцах ач холбогдолтой. Уламжлалт спортын тэмцээн уралдааныг зохион байгуулж, дүүрэг, нийслэл, улсын тэмцээнд амжилттай оролцлоо.сургуулийн дэгийг хэрэгжүүлэх, сурагчдын төлөвшил дэг журам дээр анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.Сургуулиас зохион байгуулсан үйл ажиллагаануудад тогтмол идэвхтэй оролцож ирлээ.

ТАЙЛСАН БИЧСЭН: БИЕИЙН ТАМИРЫН БАГШ

Г. ГҮНСЭНХОРОЛ

Сурагчидыг тэмцээнд бэлтгэн оруулсан байдал




Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байлал






Сургалтанд хамрагдсан байдал



БҮТЭЭЛЧ АЖИЛ



Цувран 3

СПОРТ ЗААЛАНД

УНАЖ, БЭРТЭХЭЭС СЭРГИЙЛЭЭРЭЙ



Зориулалтын хувцас, гутал өмсөх



Агааржуулалт, гэрэлтүүлэг хангалттай байх



Бэртэхээс сэргийлэх хамгаалаалт хэрэглэх



Бие халаалт заавал хийх (30 минут)



Тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах




Аюулгүй ажиллагааны дүрэм, журамтай танилцах



Гадуур хувцас солих



Аюулгүй, талбайд тоглох



facebook

twitter

youtube



ОЛОН УЛСЫН МАРАФОН ГҮЙЛТ